

“ЭРДЭНИЙН ЭРИХ” ХЭМЭЭХ МОНГОЛ
СУРВАЛЖИЙН ТУХАЙ

Д. Бүрнээ*

“Монголын оронд хааны угсаа хийгээд шашин дэлгэрсэн, шашныг баригчин үсэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оршвой” хэмээх сурвалжийг Ордосын тойн ханчэн бандид гэлэн Ишбалдан бээр арван дөрөвдүгээр жарны модон хонин жил буюу 1835 онд зохиожээ.

Ишбалдангийн “Эрдэнийн эрих” зохиолыг гадаад, дотоодын эрдэмтэд судалж тэмдэглэсэн байдаг. Оросын эрдэмтэн Л.С.Пучковский “Монгольские рукописи и ксилографы института Востоковедения” номдоо уг зохиолын нэр, зохиогч, зохиогдсон оны талаар мэдээлжээ.¹ Манай эрдэмтдээс эл зохиолын талаар эрдэмтэн Х.Пэрлээ, Ш.Нацагдорж нар судалж тэмдэглэсэн зүйл бий. Эрдэмтэн Х.Пэрлээ “Эрдэнийн эрих”-ийн товч агуулгыг дурдаад Ишбалдан “олон сурвалж бичиг, баримтыг нийлүүлэн үзэж”, “монгол өөрийн түүхийг” голчлон баримталсан...” бөгөөд “дамжиггүй болов уу” гэсэн мэдээ баримтыг хэрэглэж, түүхэн он цагийг их л нарийвчилсан байна. Түүхэн явдлыг өгүүлэх байдал нь 17 дугаар зууны үеэс их дэлгэрсэн арга барилаар Энэтхэг, Төвдийн хаадын намтар түүхээр эхэлсэн байна.

“Монголын түүхийн талаар монголчуудын дунд боржигин гэдэг ноёлог язгуур гарсан, буддын шашин дэлгэрч, шар феодалын алба бий болсон тухай сонирхолтой шинэ мэдээ саналыг гаргасан байна. Үнэтэй хэсэг нь Өмнөд монгол, Ойрадын дунд хэн хэн тэргүүлэн 17-18 дугаар зууны үед буддын шашны ямар ямар нэртэй хүрээ, хийд байгуулсан түүхийн мэдээ материал ба монгол ноёдын намтрыг нэлээд дэлгэр өгүүлсэн” явдал юм гэжээ.² Эрдэмтэн Ш.Нацагдорж “Алтан товч”-ийн зохиогчийн тухай” хэмээх өгүүлэлдээ Ишбалдангийн бичсэн зохиолд нэр дурдагдаж буй Далад хошууны Дашчойлин хийдийн мэргэний эрхт лхазун Лувсанданзанг “Алтан товч”-ийн зохиогч байж магадгүй хэмээн таамаглахын сацуу “Эрдэнийн эрих” нь түүхийн сонирхолтой бичиг болохыг дурдан, зохиогч Ишбалдан нь “Лам хүн учир Монголд шарын шашин дэлгэрсэн явдлыг нэлээд нарийвчлан гаргахыг оролдсон” хэмээн тэмдэглэжээ.³

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

¹ “Монгольские рукописи и ксилографы института Востоковедения” 1957, стр. 58-60.

² Монголын хувьсгалын өмнөх үеийн түүх бичлэгийн асуудалд, УБ, 1958.

³ Алтан товчийн зохиогчийн тухай, Шинжлэх ухаан техник, 1958, 53-р тал

“Эрдэнийн эрх”-ийн дараах судалгаа бол нэрт монголч эрдэмтэн В.Хайссигийн бүтээл юм.⁴ Дани улсын нийслэл Копенгаген хотын хааны номын санд “Эрдэнийн эрх”-ийн хоёр зүйл гар бичмэл хадгалагдаж байгаагаас эрдэмтэн В.Хайссиг Mong.420 гэсэн шифртэй сайн гаргацтай эхийг сонгон авч, гэрэл зургаар хуулбарлан буулгаж, 1961 онд оршил бичин, нэрийн хэлхээс хийж хэвлүүлжээ. Түүний судалгаанд тэмдэглэснээр “Эрдэнийн эрх”-ийг Цахарын Шулуун цагаан хошуунаас Дани улсын судлаач К.Грөнбэх⁵ 1938-1939 оны хооронд олж, анх мэдээлсэн байна. Эрдэмтэн В.Хайссиг оршил өгүүлэлдээ ханчэн бандид Ишбалдан “Эрдэнийн эрх” зохиолоо бичихдээ ашигласан гол сурвалжийн тухай, “Эрдэнийн эрх”-ийн товч агуулга, судлагдсан байдлын талаар товч өгүүлжээ. Тухайлбал: Хөх нуурын Сүмба хамба Ишбалжирын (1704-1788) 1748 онд бичсэн “Багсамжонсан”⁶, Туган Лувсанчойжинямын (1737-1802) 1802 онд бичсэн “Шэлжимэлон”⁷ хэмээх хоёр сурвалжийг ашигласан болохыг дурдаад, эдгээр сурвалжийн “Эрдэнийн эрх”-тэй агуулгаараа төстэй хэсгээс тэмдэглэн, энэ хоёр сурвалжийн хоорондын адил төстэй талыг судалж амжаагүйгээ дурджээ. Сүмба хамба Ишбалжир бол Туган Лувсанчойжинямын номын багш нь байсан бөгөөд Туган Лувсанчойжиням бээр зохиолынхоо дөрөвдүгээр бөлгийн “Монгол орноо шашин дэлгэрсэн ёс” хэмээх хэсгийг бичихдээ багшийнхаа зохиолоос ашигласан байна. Тиймээс “Багсамжонсан” хийгээд “Шэлжимэлон” хэмээх хоёр зохиол дахи Монгол орноо шашин дэлгэрсэн тухай өгүүлсэн хэсгүүд тийнхүү адил төстэй болжээ. Монгол хаадын үе залгамжийн тухай Сүмба хамбын зохиолоос, Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн, сүм хийд байгуулсан тухай хэсгийг Сүмба хамба, Туган Лувсанчойжиням нарын зохиолоос товчлон авчээ.

Саяхан болтол Ишбалдангийн зохиолыг монгол хэлээр уламжилж ирсэн гэж ойлгож байсан билээ. Харин хятад улсын эрдэмтэн Сүлүйгө 1989 онд хэвлүүлсэн “Монголын төр шашны түүх” хэмээх номдоо⁸ Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд Ишбалдангийн “Эрдэнийн эрх”-ийн төвд модон барын судар хадгалагдаж буй тухай тэмдэглэжээ. Мөн уг зохиолын агуулга, үзэл санаа, эх бичгийн талаар дэлгэрэнгүй оршил бичиж, төвд хэлнээс хятад хэлнээ орчуулжээ. Соном 2007 онд Өвөр монголд хэвлүүлсэн “Ордос тулгар бичиг- одоохь хэлний дэвтэр” (доод)-т Ишбалдангийн “Эрдэнийн эрх”-ийг нийтлүүлсэн⁹ бөгөөд оршил өгүүлэлдээ “Эрдэнийн эрх”-ийг “ордосын зүүнгар хошууны гадарма-ийн сүмийн шаврун Ишбалдан

⁴ ERDENI-YIN ERIKE Mongolische Chronik Der Lamaistischen klosterbauten Der Mongolei von ISIBALDAN (1835), In Faksimile mit Einleitung und Namensverzeichnis herausgegeben von Walter Heissig, Kopenhagen, 1961.

⁵ K.Gronbech, Sprog og Skrift i Mongoliet, Geografisk Tidsskrift 43:1940 //ERDENI-YIN ERIKE Mongolische Chronik Der Lamaistischen klosterbauten Der Mongolei von ISIBALDAN (1835), In Faksimile mit Einleitung und Namensverzeichnis herausgegeben von Walter Heissig, Kopenhagen, 1961.

⁶ Ye shes dpal 'byor, 'Phags pa yul rgya nag chen po bod dang sog yul du dam pa'i chos byung tshul dpag bsam ljon bzang zhes bya ba.Dgon lung byams pa gling gi dpar. Rab byung bcu gsum pa'i sa pho 'brug lo.

⁷ Grub mtha' thams cad kyi khungs dang 'dod tshul ston pa legs bshad shel gyi me long. Dgon lung byams pa gling gi dpar, Лувсанчойжинямын сүмбүмийн “На” боть.

⁸ 耶喜巴勒登, 蒙古政教史, 注·格, 民族出版社, 北京, 1989.

⁹ Ordus tulgur bichig-odoqi kelen-u debter (dooradu), 2007, 837

төвд хэлээр бичиж, өөрөө модон бараар барласан”¹⁰ гээд “тус зохиолыг Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалж буй”¹¹ тухай мэдээлжээ.

Ингэхдээ монгол хэлээр уламжилж ирсэн “Эрдэнийн эрих”-ийг хэн монгол хэлнээ хөрвүүлсэн талаар дурдаагүй бөгөөд 1957 онд монгол хэл бичиг түүх судлах газрын Саян-Ойдов төвд хэлнээс монголчилсон гар бичмэл болон В.Хайссигийн хэвлүүлсэн монгол эх хоёрыг харгуулан үзэж шинэчлэн найруулж хэвлүүлснээ тэмдэглэжээ.

Ишбалдангийн “Эрдэнийн эрих”-ийг төвд хэлнээс орчуулсан байж болохыг түүний зохиолын найруулга харуулж байна. Тухайлбал, төвд хэлний тодотгол ихэнхидээ тодотгуулагчийн хойно ордгийг хуулбарлан буулгажээ. Жишээ нь, равжун дөрөвдүгээр, хаан Тогоонтөмөр, хаан Чингис, хаан Өгөдэй, тэнгэрийн ширээт долоо гэх мэт. Мөн төвд үг нэлээд тааралдана. Жишээ нь: гавзай, гонзог, аг, жүд, брүлва, ритод, цанид, дацан, гүнда, дүлба, ринбүчи, лам, ханчэн, ламрим, шавдун, банчэн, гүсүнтүг, ван, савдаг, цомбу, гэлэн, гэцэл, лхахан, шүншүг гэх мэт. Энэ нь 19-р зууны монгол хэлэнд төвд үг ихээр нэвтрэн орж байсныг харуулах баримт болох бүлгээ.

“Эрдэнийн эрих” зохиол нь үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ¹². Нэгдүгээр хэсэгт монгол хаадын угсаа гарлын тухай өгүүлнэ. Үүнд энэтхэгийн Олноо өргөгдсөн хаанаас улбаатай Төвд хаадаас Монгол хаад гарал үүсэлтэй болох тухай, Чингисээс Даян хаан хүртэлх хаадын товч түүх, Өвөр Монголын хошуудад ноён суусан Чингисийн дүү нарын залгамжийн тухай, Тогоонтөмөрөөс дээш арван зургаан хаан “их хаан”, Тогоонтөмөрийн хүү Билигтээс доош хаад “бага хаад” гэгдэх болсон тухай, Цагаадай, Зүч болон тэдгээрийн улс, эзэмшлийн тухай, Өөлд, Зүүн гар, Торгууд, Ордос, Отог, Хангин, Үүшиний ноёдын угсаа гарлын тухай, Өөлдийн хаан Галдан бошогт Халхыг эзэлж, Жэвзүндамба тэргүүтэн ихэс лам нар Манжийн хаанаас тусламж гуйн, Манжийн Энх-Амгалан хааны цэрэг Галдан бошогтыг дарсан тухай голлон бичжээ.

Зохиолын хоёрдугаар хэсэг “Монголын оронд шашин дэлгэрсэн хийгээд үсэг урлаж, судар шастир хятад, төвдөөс орчуулсан хийгээд хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсан ёс нь” гэсэн нэртэй. Хятадын У Ди хааны үед (МЭӨ 140 он) монгол цэргийн эд бараан дотроос Бурханы хөрөг олдсон хэмээх мэдээнд тулгуурлан, Бурханы шашин Монгол оронд эрт буюу Хятадад дэлгэрэхээс өмнө дэлгэрсэн тухай, Монгол орноо анх Төвдийн Сажагийн номын ёс, улмаар Гармава, Гэлүмбагийн номын ёс дэлгэрсэн, төвдийн Сажаба, Гармава, Гэлүмбагийн лам нартай монгол хаад номын барилдлага тогтоосон, Түмэдийн Алтан хаан гуравдугаар Далай лам Содномжамц нарын барилдлагаас эхэлж, Монгол орноо бөө мөргөлийн харгис ёсыг халж, шарын шашны номын ёс дэлгэрэх болсон, монгол гаралтай дөрөвдүгээр Далай лам Ёндонжамц монгол орноо шарын шашныг дэлгэрүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн тухай, бурханы зарлиг сургаал хийгээд их бага таван ухааны цоморлиг болох Ганжуур, Данжуурыг орчуулсан, бурханы шашны Эрдэнэ зуу тэргүүтэй сүм хийдийг үүсгэн байгуулсан, Сажа бандид Гунгаажалцан монгол хэлний зүйг, Пагва лам бичиг үсэг зохиосон тухай, бурханы шашныг дэлгэрүүлэхэд Хошуудын Гүүш хаан их үйл үйлдсэн тухай, Халх, Өөлдийн хямрал, Халхын Цогтын тэмцлийн тухай, Зүүн гар, Торгууд, Ордос, Үүшин

¹⁰ Ordus tulgur bichig-odoqi kelen-u debter (dooradu), 2007, 837

¹¹ Ordus tul0ur bi7ig-odoqi kelen-2 debter (dooradu), 2007, 838

¹² В.Хайссигийн хэвлүүлсэн “Эрдэнийн эрих”-ийн монгол эх тусгайлан ялгасан хоёр бөлөгтэй бөгөөд хоёрдугаар бөлгийн төгсгөлийн “бас бүтээлийн аймаг тэргүүтэн ямар мэт гарсан ёсыг өчүүхэн өгүүлэх нь” гэсэн хэсгийг Өвөр монголын эрдэмтэн Сүлүйгө, Соном нар тусд нь нэг бөлөг болгож, улмаар гурван бөлөгт ангилан хуваажээ.

зэрэг Өвөр Монголын олон хошуудад сүм хийд байгуулагдсан тухай өгүүлжээ. Судрын төгсгөлийн үгэнд Ишбалдан номоо хаана, хэний захиасаар, хэрхэн бүтээснээ тэмдэглэжээ. Тухайлбал, Ордосын Дамчойдаржайлин хийдийн харьяа Лавран Санхагравжайлин хийдэд “судар тарни даяарыг мэдэхийн нүдэн лүгээ төгссөн эрдэнэ хамба тойн шавдун Агвандашижунай бээр шамдал ихээр дахин дахин дуртгасанд шүтээж”, “шашин амьтан нийтэд түргэн туслах” зорилгоор “чойнжун хийгээд дэвтэр тэргүүтнээс түүж”, “сайтар эвлүүлэн” бүтээсэн ажээ.

Ханчэн бандид Ишбалдангийн гол барьж ашигласан зохиол бол Хөх нуурын Сүмба хамба Ишбалжирын “Багсамжонсан”, Туган гэгээн Лувсанчойжинямын “Шэлжсимэлон” хэмээх төвд хэлээрх сурвалж юм. Сүмба хамба Ишбалжирын “Багсамжонсан”-г голлон ашиглах явцад уг сурвалж дахь мэдээг тодруулах үүднээс “Хөх дэвтэр”-ийг үзжээ. Тухайлбал, Сүмба хамбын зохиолд Хоричар мэргэн гэж бичээд Бадмажунай гэж тодотгон тайлбарласныг Ишбалдан ашиглахдаа, энэ мэдээ “Хөх дэвтэр”-т байдгийг тэмдэглэжээ. Зохиолын тэргүүн хэсгийг бичихдээ Сүмба хамбын “Багсамжонсан”-г ашиглажээ. Энэхүү сурвалжийг ашиглахдаа завсар зуур нь нэмэн бичсэн буюу бусад сурвалжаас үг, өгүүлбэр оруулсан байдалтай. “Багсамжонсан”-гаас авсан зүйл бол Махасамади хаанаас хойш олон сая жил өнгөрсний хойно Төвдийн Хүзүүн сандалт хаан гарч, түүний удмын Дигүмзан хааны отгон хөвгүүн Нидив, монгол нэр нь Бодоши хэмээгч бээр Гонбо орноо очиж, Гоо марал хэмээх хатнаа дагуулан, Монгол орноо ирснээс монголчуудын удам гарсан, Бодончар бээр Махасамади хаанаас гаралтай болох тухай, Бодончараас Есүхэй баатар хүртэлх хаадын залгамж үе, Тэмүжиний Чингис хаан хэмээн өргөмжлөгдсөн хэсэг, Чингис хаан Манж Жүрчидийн улсаас эхлэн, Төвдийн Миняг хүртэлх улс орныг эрхэндээ оруулсан тухай, Чингисийг Тангудын хааны хатан хорлосноос Чингис хаан нас нөгчсөн тухай домог, Чингисийн үр хүүхдийн тухай, Хубилайгаас Лигдэн хүртэлх хаадын тухай, Лигдэнгийн хатан, хүүхдүүд Манжид дагаар орсон тухай өгүүлнэ. Цаашилбал, хаад хэдэн жил хаан ширээнд суусан, Чингис хааны их хөвгүүн Цагаадай, Зүчээс улбаатай хааны угсаа, Зүүн гар, Чорос, Хошууд, Торгууд ноёдын үе залгамжийн тухай, Өөлдийн хаан Галдан Бошогтын тэмцлийн тухай, Галданцэрэнгээс Даваач хүртэлх Өөлд хаадын удам, Өөлдийн баруун хошууны ноёдын угсаа буюу Хасарын удмын тухай өгүүлжээ. Өөрөөр хэлбэл уг зохиолын тэргүүн хэсгийн гуравны хоёрыг бичихдээ Сүмба хамбын төвд хэлээр бичсэн “Багсамжонсан”-гаас товчлон орчуулж авчээ. Ишбалдан бээр Сүмба хамбын зохиолоос орчуулан авахдаа зарим зүйлийг засан найруулж, зарим мэдээг тодруулжээ. Зассан зүйлийн тухайд “Хөх дэвтэр”-т “Чингис хаан усан барс жил мэндэлсэн бөгөөд сүүдэр гучин наймд хааны ширээнд сууснаас гал гахай жилд Минягийг авч, усан барс жилд хальсан хэмээдэг боловч хятад монголын шинэ хуучин түүх бичигтэй зохилдохгүй” хэмээн Сүмба хамбын бичсэнийг “Монгол өөрийн түүх лүгээ нийлэхгүй” хэмээн хятад гэсэн үгийг орхижээ. Энэ нь зохиогчоос хятад сурвалж бичиг ашиглаагүйтэй холбоотой байж болох талтай. Түүнчлэн Ишбалдан бээр Сүмба хамбатай санаа нийлэхгүй зүйлээ орхиж, өөрийн санааг бичжээ. Тухайлбал Сүмба хамба Чингисийн таван дүүгийн нэрийг дурдсан бол Ишбалдан Бүгэвандарын нэрийг орхисон, Лигдэн хаан “модон туулайгаас гучин нэгэн жил хааны сууринд суусан” гэснийг “Лигдинбаатар усан луу жилт тэр бээр модон хонин жилээс равжун арван нэгдүгээр усан тахиаг хүртэл гучин жил хааны төрийг тэтгэвэй” гэж засжээ. Мөн Сүмба хамбын зохиолд “бүдүүн биеийг хуучин хуурцагт орхиж, арилсан оронд залрав” (sku rags pa rnying ba'i za ma tog dor te dag zhing du byon) гэсэн хэллэгийг Ишбалдан

бээр “дүрс биеийн томъёог хуучин оронд орхиод, арилсан оронд заларсан” гэж засан найруулжээ.

Ишбалдангийн зохиолд тодруулгын чанартай нэмж бичсэн зүйл бий. Жишээ нь: Сүмба хамба монгол хаадын хаан ширээнд суусан жилийн махбодыг дурдсан төдий бол Ишбалдан тухайн хаад ямар махбод бүхий жил хүртэл хэдэн жил хаан суусныг тодорхой тэмдэглэжээ. Түүнчлэн Сүмба хамбын зохиолд “Хөх дэвтэр”-ийн зохиогчийг дурдаагүй бол Ишбалдан бээр Идсанзэва Шоннубал зохиосон хэмээн дурдсан байх жишээтэй. Мөн Сүмба хамбын зарим санаа дүгнэлтийг хэвээр авчээ. Тухайлбал “Тэр мэт Монгол, Төвдийн бичиг данс заримд элдэв зүйлийг өгүүлсэн боловч Сажса хийгээд Монголын хуучин түүх угсаа ариун мэт байгуулсан тул өчүүхэн нэгэн эндүүрсэн байвч мөн бүхэнд дамжиггүй болов уу хэмээн санагдмуй” гэжээ. Хаадын нэрийн бичлэгийн тухайд Сүмба хамбын бичсэнтэй ихэнхидээ таарах боловч ялгаатай бичсэн зүйл ч байна. Жишээ нь

Сүмба хамба	Ишбалдан	Монголын нууц товчоо
Чоро	Чуухур	Čeren
Мангүлиг Сүлдэ		Мэгүлэг Сүлди Megüleg
Годан	Гүдэн	-
Бүлтэгэлжин	Бөртэгэлжин	Börte-üjin
Охэдай	Огидай	ögödei
Хүрэ түмэд	Хүри түмэд	Qori tumat
Балгудай	Билагуд	Belgütei
Багундай	Бигандэй	Bügünütei
Шалчэгуд	Шалчигуд	Salji'ut

“Эрдэнийн эрих”-ийг Сүмба хамбын “Багсамжонсан”-гийн тохирох хэсэгтэй тулгаж үзэхэд алдаж бичсэн зүйл мэр сэр бий. Жишээ нь: “Лусын хаан өвчин туссан” гэсэн өгүүлбэрийг Сүмба хамбын номд “Лусын өвчин тусав” буюу төвдөөр “лүнаджи тэв” гэжээ. Үүнд “хаан” гэсэн үгийг эндүүрч илүү бичсэн бололтой. Цаашилбал, “Баянмөнх гал бичин жилт тэр бээр шороон хулгана, шороон үхэр хоёр жилд хаан ширээнд суув” гэсэн өгүүлбэрийг Сүмба хамбын зохиолтой харгуулан үзвэл “Баянмөнх гал бичин жилт тэр бээр шороо хулгана”-д хаан ширээнд суусан гэжээ. Энд “шороон үхэр хоёр” гэсэн хэсэг илүү байна. Зүүн гарын ноёдын удмын нэрсийн дотор “хохитажу, батулагсан” гэж бичсэнийг Сүмба хамбын зохиолтой харгуулж, Гохи даёо, Батула чинсан гэсэн хүний нэр болохыг мэдэв. Гохи даёо буюу Хуухай Таюу бол Зүүн гар аймгийн Бөхэ ханы ач хүү болно. Хуухай Таюугийн хүү Батула чинсангийн нэрийг эндүүрч Батулагсан гэж бичжээ. Эхийн дотор нэг үгийг хэдэн янз бичсэн тааралдана. Жишээ нь, *шажин–шашин, Тулуй–Тулу-а, Хубалай–Хубилай, Лигдэн–Лигдин–Лэгдэн, Шигэмүни–Шигэмүни, ахуй–агуу* гэх мэт. Монгол бичгийн зөв бичих дүрмээс хазайсан зүйл байна. Эр үгэнд эм үгийн нөхцөл залгасан, тийн ялгалын нөхцөлийг өмнөх үгтэй нь заримдаа хамт бичсэн, үгийн эхэнд орсон “га” дээр цэг тавиагүй орхисон, үгийн төгсгөлд дэвсгэрлэж орсон “г”, “с” гийгүүлэгчийг ижил дүрстэй бичсэн зэрэг зүйл ажиглагдана. Энэхүү зөрөөг бид эхийн онцлогийг хадгалах үүднээс засахгүй хэвээр буулгав.

Ишбалдан бээр ханчэн бандид цолтой хүн байснаас үзвэл тэрээр буддын их таван ухаанд мэргэшсэн, хүрээ хийдийн номын ширээг эрхшээн суусан эрдэмтэн лам байжээ.

Тиймээс ч төвд хэлээрх монгол, төвд хоёр эрдэмтний бичсэн олноо нэр алдаршсан чойнжун, бусад дэвтэр тэргүүтнийг ашиглан эл зохиолоо бичжээ. Тэрээр дундад зууны монголын түүхч эрдэмтэн лам нарын нэгэн адил монгол хаадын гарлыг энэтхэг төвдөөс гаралтай, Монголд бурханы шашин Хятадад дэлгэрэхээс өмнө Монголд дэлгэрсэн хэмээн үзэж, Халхын Цогт *“шарын шашинд хорлолыг гүйцэх чинээгээр үйлдсэн”* хэмээн бичжээ. Мөн монгол хаадын хаан суусан он цагийн талаар төвд сурвалжид бичсэн зүйл *“монгол өөрийн түүх лүгээ нийлэхгүй”*, *“монгол өөрийн түүх угсаа ариухан”* учир монгол сурвалжийн мэдээ үнэн зөв болохыг тэмдэглэжээ.

Ишбалдан монгол хаадын нэрийг хаан суусан он жилтэй нь жагсаан бичээд *“дэлхий дахиныг тэтгэгч хаан тэр нүгүүдийн үед төрийн үндсэн эс сөнөсөн энэ адил их хаан гүрэн хойшид гарсан үгүй”* хэмээн бичсэнээс нь үзвэл Манжийн дарлалд байсан өөрийн үеийнхэнд үүх түүхээ танин мэдүүлэх, үндэс угсаагаараа бахархах сэтгэлийг төрүүлэх зорилгоор энэхүү зохиолоо бичсэн нь харагдана.